

## Хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой стандартын мэдээллүүд

### Хүнсний хууль эрх зүйн хорооны талаар

НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын 1961 оны 11 дүгээр чуулган, ДЭМБ-ын 1963 оны 5 дугаар сарын 16 дугаар чуулганаас ХХААБ/ДЭМБ-ын хамтарсан Хүнсний стандартын хөтөлбөр бий болгох тогтоол гарснаар Хүнсний хууль эрх зүйн Хороо /Codex Alimentarius Commission/ байгуулагдаж, дүрэм, үйл ажиллагааны журам баталж, өнөөдөр 185 гишүүн орныг эгнээндээ нэгтгээд байна.



Монгол Улс нь Дэлхийн Худалдааны байгууллагад 1997 оны 1 сард гишүүнээр элсэн орж, Худалдаан дахь Техникийн Саад тотгорын Хэлэлцээр ёсоор хүнсний худалдаанд оролцохдоо НҮБ-ын ХХААБ, ДЭМБ-ын хамтарсан Хүнсний хууль эрх зүйн хороо (ХХЭЗХ)-ны стандарт, техникийн баримт бичгүүдийг мөрдөх, Монгол Улсын үндэсний стандартуудыг ХХЭЗХ-ны стандарт, удирдамж шийдвэрт нийцүүлэх үүрэг хүлээж, гадаад худалдаанд нийлүүлж буй бүтээгдэхүүн нь Олон Улсын Ариун цэвэр, ургамал хорио цээрийн Хэлэлцээрт заасан шаардлагуудыг хангасан байх ёстойг хүлээн зөвшөөрсөн.

## “Хүнсний нэмэлт” стандартын тухай



Техник, технологи өргөжин хөгжихийн зэрэгцээ хүнсний бүтээгдэхүүний өнгө, үнэр, амт болон биет байдлыг сайжруулах, хадгалалтын хугацааг уртасгах, технологи ажиллагааг хурдасгах зорилгоор хүнсний нэмэлтийг өргөн хэрэглэх болсон. Хүнсний нэмэлт нь дангаараа бүтээгдэхүүн, эсхүл хүнсний үндсэн бүрэлдэхүүн хэсэг болж чаддаггүй, тэжээллэг чанаргүй хүнсний үйлдвэрлэлийн явцад зориудаар нэмдэг бодис, хольц юм.

Хүнсний бүтээгдэхүүний найрлагад орж болох хүнсний нэмэлтийн зохистой хэрэглээ ба ямар хүнсний бүтээгдэхүүний найрлагад хэдий хэмжээтэйгээр байж болох талаар стандартыг Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 12 дугаар сард шинэчлэн баталсан.

Энэхүү стандартыг Хүнсний хууль эрхзүйн хорооноос батлан гаргасан стандартыг орчуулан боловсруулсан бөгөөд олон улсдаа 2016 онд нэмэлт өөрчлөлт орсон байна.

“MNS CAC 192:2015, Хүнсний нэмэлт” стандартын Норматив эшлэл хэсэгт заахдаа хэрэв эш татсан стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх хувийг баримтална гэж заасны дагуу <http://www.fao.org/fao-who-codexalimentarius/en/> цахим хуудаснаас НҮБ-ийн албан ёсны хэл болох англи, франц, испани, хятад 4 хэлийн аль хүссэн хэлээр сонгон үзэх боломжтой юм. Одоогоор Араб болон орос хэлнээ хараахан орчуулагдаагүй байгаа болно.

## “Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага”

### стандартын тухай



Хүнсний бүтээгдэхүүний сав, боодол дээр байгаа шошгыг хэрхэн бичих талаар Хүнсний хууль эрхзүйн хорооноос батлан гаргасан стандартуудыг үндэсний болгон орчуулан боловсруулж “MNS CAC 1:2007, Савласан хүнсний бүтээгдэхүүний шошгололтод тавих ерөнхий шаардлага”, “MNS CAC GL 2:2007, Шим тэжээлт чанарыг шошгод тусгах зөвлөмж” гэсэн 2 нэрийн стандартыг хэрэглэж ирсэн.

Дээрх стандартуудын эх хувьд нэмэлт өөрчлөлт орсны улмаас сайжруулах шаардлага тулгарч ЭМЯ, НЭМҮТ санаачлага гарган дахин хянах ажлыг гардан ажиллаж “MNS 6648:2016, Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага” стандартыг батлуулсан.

Хүнс үйлдвэрлэгч, худалдаа эрхлэгч нарт бэлтгэл ажил хангуулах үүднээс уг стандартыг хэрэгжүүлж эхлэх хугацааг 2017 оны 7 сарын 1-ний өдрөөр тогтоосон.

Энэхүү стандартад заасан хуучин стандартаас ялгаатай зарим шаардлагыг дурдвал:

- а) **5.2.1.1** Орц бүрдүүлэгчийн жагсаалт нь “орц” гэсэн тодотголтой байна. /урд нь найрлага буюу найрлага бүрдүүлэгч гэдэг байсан./
- б) **5.12 Шимт бодисын мэдэгдэл**
  - 5.12.1** Хүнсний бүтээгдэхүүний найрлагын өвөрмөц шинжийг шошго дээр тусгайлан мэдээлж болно. Үүнд энэ стандартын **5.11** зүйлд дурьдсан мэдээлэл хамаарахгүй.
  - 5.12.2** Тухайн хүнсэнд агуулагдах аль нэг шимт бодисын талаар мэдэгдэл гаргасан бол түүний агууламжийн талаар заавал мэдээлнэ.
- в) **5.13 Эрүүл мэндийн мэдэгдэл**
  - 5.13.1** Дараах шаардлагыг хангасан тохиолдолд хүнсний бүтээгдэхүүний шошго дээр эрүүл мэндийн мэдэгдэл гаргаж болно. Үүнд:
    - 5.13.1.1** Мэдэгдэл нь шинжлэх ухааны үндэслэлтэй нотолгоонд суурилсан, эрүүл мэндийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллагаар хүлээн зөвшөөрөгдөж батлагдсан байна.
    - 5.13.1.2** Мэдэгдэл нь зохистой хооллолтын дадлыг зөрчих, аливаа хүнсийг хэтрүүлэн хэрэглэхийг дэмжсэн байж болохгүй. гэх мэт

## “Шимийн архи. Техникийн шаардлага”

### стандартын тухай



Монгол улсад үйлдвэрлэж байгаа архины технологи нь Орос улсын уламжлалт ундаанд хамаардаг бөгөөд энэ бүтээгдэхүүнийг Монголчууд 19-р зууны сүүл үеэс хэрэглэж эхэлсэн гэж үздэг. Харин өв уламжлалаас харахад Монголчуудын уламжлалт бөгөөд спирт агуулсан ундаа бол малын сүүнээс нэрж гаргадаг шимийн архи юм.

Шимийн архи нь ямар шаардлага хангасан байх ёстой талаар “MNS 5074:2001, Дарс, дарсны төрлийн бүтээгдэхүүн” стандартад туссан байсан хэдий ч энэхүү стандартыг 2009 онд хянаж шинэчлэх явцад шимийн архи нь сүү, сүүн бүтээгдэхүүний ангилалд хамаарна гэж үзээд тухайн стандартаас хассан бөгөөд өнөөг хүртэл зохицуулах техникийн баримт бичиггүй байсан юм.

Иймд хүний биед сөрөг нөлөө нэн бага бөгөөд учир нь малын сүү шимээс нэрж гаргадаг үндэсний уламжлалт “брэнд” бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих, өв уламжлалыг сэргээхэд шимийн архины бие даасан стандартыг боловсруулж үйлдвэр аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд мөрдүүлэх шаардлага зүй ёсоор урган гарсан болно.

Шимийн архи нь этилийн спиртийн агууламж бага, метилийн спирт бараг агуулдаггүй онцлогтой болохыг 2011-2016 онд 8 аймгийн 32 суманд бэлтгэсэн шимийн архины дээжинд хийсэн судалгаа болон лаборатори, үйлдвэрлэлийн туршилтын үр дүнгээс харж болох юм.

Энэхүү судалгааны дүнд үндэслэн боловсруулсан “MNS 6653:2017, Шимийн архи. Техникийн шаардлага” стандартыг Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар баталлаа.

## “Цөцгийн тос. Техникийн шаардлага”

### стандартын тухай



Монгол улс мал аж ахуйн орон билээ. Дэлхийн олон оронд цөцгийн тос буюу бидний хэлж заншснаар “масло” гэх бүтээгдэхүүнийг сүүлийн үед ургамлын гаралтай тосоор үйлдвэрлэх технологи нэлээн хөгжөөд байгаа билээ. Иймд хэрэглэгчийг төөрөгдүүлэхгүйн үүднээс малын сүүнээс гаргаж авсан цөцгийн тосны стандартыг тусад шинээр боловсруулах ажлыг хийж энэхүү стандартад ургамлын гаралтай тосноос ялгах ялгааг тусгаж өгсөн. Энэхүү “MNS 6652:2017, Цөцгийн тос. Техникийн шаардлага” стандартыг [www.estandart.mn](http://www.estandart.mn) цахим хуудаснаас үзэж танилцах боломжтой.

### Стандарттай хэрхэн танилцах вэ?

#### 1. Үйлчилгээний танхимаар:

СХЗГ-ын дэргэдэх Стандартын мэдээлэл, лавлагааны төв, аймгуудын Стандартчилал, хэмжилзүйн хэлтсүүдэд очиж үйлчлүүлж болно.

#### 2. Интернетээр:

[www.estandart.gov.mn](http://www.estandart.gov.mn) вэб хуудас

Та сонирхсон стандартаа түлхүүр үгээр, стандартын ангилалтын кодоор, дугаараар хайлт хийж, бүрэн эхээр нь үзэж танилцах боломжтой.